



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 87

Эрдэнэт

Аймгийн сонгуулийн хороо
байгуулах тухай

Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах аймгийн сонгуулийн хороог хавсралтад дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт заасны дагуу сумын сонгуулийн хороог байгуулахыг аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Сонгуулийн тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг аймгийн сонгуулийн хороо /Д.Мөнхболд /-нд даалгасугай.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА